



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 477

Улаанбаатар хот

“Грийт секьюритис” ХХК-ийн брокер, дилер, хөрөнгө
оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, 13.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тухай журам”-ын 8.1.2, 8.1.3, 8.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоох нь:

1. “Грийт секьюритис” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй.
2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд Хорооноос өгсөн үүрэг даалгавар, албан шаардлагын биелэлтэд гаргасан зөрчил, дутагдлаа арилгаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг “Грийт секьюритис” ХХК /Б.Өлзийбаяр/-д анхааруулсугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

380017